



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/423

Эрдэнэт

Шагнах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрдэнэт хотын Хүндэт иргэн” шагналын журмын 7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 90 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орхон аймаг, Эрдэнэт хотын бүтээн байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулсан онцгой хувь нэмрийг үнэлж Гомбосүрэнгийн Гэндэнжанхар, Санжаажавын Сэндэнгарам, Дэмбэрэлдашийн Дашмаа, Сүрэнгийн Лхаажав нарыг “Эрдэнэт хотын Хүндэт иргэн” медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулсугай.

2. Шагналд зарцуулагдах 4000000, өргөмжлөлийн 320000 төгрөг, нийт 4.320.000 / Дөрвөн сая гурван зуун хорин мянган / төгрөгийг хавсралтаар баталж, орон нутгийн бусад зардлын шагнал урамшууллын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 623 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/Д	Арга хэмжээ	Зардал/ нэгж/	хэмжээ	Нийт
1	Мөнгөн шагнал: -С.Сэндэнгарам -С.Лхаажав -Г.Гэндэнжанхар -Д.Дашмаа	1000000 төг 1000000 төг 1000000 төг 1000000 төг	4 хүн	4000000 төг
2	Өргөмжлөл	80000х4=320000 төг	4 хүн	320000 төг
	Нийт			4.320.000 төг